



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №2


2020 оны 01 дүгээр сарын 06-10

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 4 яаралтай дуудлагыг хүлээн авсан. Эдгээрийн 1(25%) хачигт халдвар, 1(25%) галзуугийн эрсдэлд өртсөн, 2(50%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.


1.1 Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол

Өмнөговь аймгийн Даланзадгад сумаас галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 1 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 99.9%-иар бага байна. Эпидемиологийн 1 дүгээр долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол

Архангай аймгийн Ихтамир сумаас хачгаар дамжих халдварын 1 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 99.9%-иар бага байна. Эпидемиологийн 1 дүгээр долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



1.3 Бэтэг өвчний сэжигтэй тохиолдол

Баянхонгор аймгийн Баянхонгор, Баян-Овоо сумаас бэтэг өвчний онош тодруулахаар 2 тохиолдлын шинжилгээний материал хүлээн авсан.

1.4 Мэрэгч амьтны дуудлага

Нийслэлийн СХД-ийн “Эмээлт” АТШН товчоо, ХУД-ийн Морингийн постноос ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага) 2 удаагийн дуудлагад үйлчилж, эрсдэлийг тодорхойлохоор лабораторийн шинжилгээ хийж байна. Он гарсаар нийслэлийн 2 дүүргийн хэмжээнд нийт 4 удаагийн амьтны дуудлагад үйлчилсэн байна.

ХОЁР. ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны өвчлөл бүртгэгдээгүй байна.

Олон улсад:

Шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа өвчин:

ДЭМБ БНХАУ дахь Суурин төлөөлөгчийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-нд мэдээлснээр Хубэй мужийн Үхань хотод “шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа” өвчин бүртгэгдсэн тухай нийтэлсэн байна.

- Үхань хот 19 сая хүн амтай
- Хубэй муж 58 сая хүн амтай

2020 оны 01 дүгээр сарын 03-ны байдлаар шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа өвчний 44 тохиолдол бүртгэгдснээс 11 тохиолдлын биеийн байдал хүнд 33 тохиолдол нь биеийн байдал тогтвортой байна. Тохиолдлуудад ихэвчлэн халуурах, зарим тохиолдолд амьсгал давчдах шинж тэмдэг илэрсэн байна.

Үхань хотын далайн бүтээгдэхүүн зардаг захыг хаасан байна. Ихэнх тохиолдлууд далайн бүтээгдэхүүн зардаг захтай холбоотой ба ариутгал халдваргүйтгэл хийсэн байна. Одоогийн байдлаар 44 тохиолдол эмчлэгдэж байна. Тандалт судалгаа үргэлжилж байна.

Эх сурвалж: ДЭМБ

Шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа өвчин:

БНХАУ-ын Хубэй мужийн Үхань хотод “шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа” өвчин бүртгэгдсэн байна. Үхань хотод одоогийн байдлаар нийт 59 тохиолдол эмчлэгдэж байна. Үүнээс 7 тохиолдлын биеийн байдал хүнд 163 хавьтлыг хяналтад авсан. Ихэнх тохиолдлууд далайн гаралтай бүтээгдэхүүн зардаг захтай холбоотой байна.

ДЭМБ-ын эрсдэлийн үнэлгээгээр БНХАУ-ын хэмжээнд өндөр, бүсийн хэмжээнд дунд, олон улсын түвшинд байга эрсдэлтэй байна. Тандалт судалгаа үргэлжилж байна.

Эх сурвалж: outbreaknewstoday.com

MERS-CoV-ийн халдвар:

Саудын Араб улсын Эрүүл Мэндийн Яамны 2020 оны эпидемиологийн 1 дүгээр долоо хоногийн эргэн мэдээллээр MERS-CoV-ийн халдварын сэжигтэй 2 тохиолдол бүртгэгдсэн байна. Эхний тохиолдол 48 настай, эрэгтэй. Алмедина дүүрэгт амьдардаг. Хоёрдахь тохиолдол 72 настай, эрэгтэй. Ридах дүүрэгт амьдардаг байна. Дээрхи 2 тохиолдол халдвартай тохиолдолтой хавьтал болсон өгүүлэмжгүй байна.

Эх сурвалж: Promed

Шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа өвчин:

Shanghai Observer сайтад “шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа” өвчнөөр 2020 оны 01 дүгээр сарын 09-ний 10:30 цагт Фудангийн их сургуулийн харьяа Шанхай хотын олон нийтийн эрүүл мэнд, Намын хорооны Нарийн бичгийн дарга, халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн профессор Лу Хонгжоуг ярилцлага өгчээ.

Коронавирусийн халдвар дэлхий даяар түгээмэл тохиолддог. Олон нийт сандрах шаардлагагүй гэж мэдэгджээ. Коронавирус нь амьсгалын замын болон гэдэсний өвчин үүсгэдэг эмгэг төрүүлэгчийн нэг төрөл. Энэ төрлийн вирусийн гадаргуу дээр тогтмол зохион байгуулалттай олон тооны талстууд байдаг бөгөөд вирусийн бүхэл талст нь эзэн хааны титэм шиг байдаг тул "Коронавирус" гэж нэрлэжээ. Одоогийн байдлаар хүний зургаан төрлийн коронавирус байдаг. Эдгээрийн дотор (hcov-229e, hcov-nl63, hcov-oc43, hcov-hku1) 4 төрөл нь коронавирүсээр халдвар авсны дараа өөрсдийгөө хязгаарладаг ба ихэвчлэн хамар битүүрэх, хамраас нус гоожих, найтаах зэрэг "энгийн ханиад"-ны шинж тэмдгүүд зарим тохиолдолд мэдрэлийн хүндрэлийн шинж тэмдэг илэрдэг байна. Гэсэн хэдий ч SARS, коронавирүс нь өндөр эмгэг төрүүлэгч чанартай тул уушгины хатгаагаар хүндэрч үхэлд хүрч болно гэж мэдээлжээ.

Энэхүү 2 коронавирүсийн эмнэлзүйн шинж чанарууд нь ижил төстэй ба халуурах, толгой өвдөх, булчин өвдөх, ядрах гэх мэт шинж тэмдгүүд илрэх бөгөөд зарим тохиолдолд амьсгал давчдах, амьсгаа боогдох, амьсгалын замын дутагдалд орох, зарим тохиолдолд суулгах зэрэг хоол боловсруулах зам, бөөрний цочмог үрэвсэл гэх мэт бусад эрхтэн тогтолцооны үйл ажиллагаанд гэмтэл илэрдэг байна.

Коронавирүсийн халдварын эмчилгээ нь ихэвчлэн шинж тэмдгийн эмчилгээний шинж чанартай байдаг. Лу Хончжоу хэлэхдээ халуурах (биеийн температур $\geq 38^{\circ}\text{C}$), уушгины хатгалгаатай адил өвчний эрт хугацаанд цагаан эсийн ерөнхий тоо буурах эсвэл хэвийн байх, лимфоцитын төрлийн тоо буурах, бактерийн эсрэг эмийн стандарт эмчилгээг хийсэнээс хойш 3-5 хоногийн хугацаанд нөхцөл байдлыг эрс сайжруулаагүй эсвэл хурцадмал байдлын клиник шинж чанарыг харуулсан тохиолдолд уушгины хатгалгааны тодорхойгүй шалтгааныг авч үзэх шаардлагатай гэж мэдэгдсэн байна.

Эх сурвалж: <https://www.shobserver.com/baijiahao/html/199634.html>


Шалтгаан нь тодорхойгүй уушгины хатгалгаа өвчин:


2020 оны 01 дүгээр сарын 07-ны 21:00 цагт шинжээчдийн бүлгийн урьдчилсан үнэлгээгээр лабораторид коронавирүсийн шинэ төрөл илэрч, вирусийн геномын бүх дарааллыг олж, коронавирүсийг нуклейн хүчил илрүүлэх аргаар ирүүлжээ. Эерэг үр дүн бүхий 15 тохиолдолд уг вирусийг эерэг өвчтөний дээжээс тусгаарлаж, электрон микроскопоор коронавирүсийн ердийн дүр төрхийг харуулсан байна.

Эх сурвалж: www.dwnnews.com

Эбола вируст халдвар:

2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад эбола вируст халдварын сэжигтэй 3392 тохиолдол бүртгэгдсэнээс 2235(66%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1903(56%) нь эмэгтэйчүүд, 956(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзлэж байна.





Эх сурвалж: ДЭМБ

MERS-CoV-ийн халдвар:

ДЭМБ-ын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн мэдээллээр 2012 оноос хойш MERS-CoV-ийн халдвараар 2494 тохиолдол, 858 нас баралт бүртгэгдсэн талаар нийтэлсэн байна.

Эх сурвалж: ДЭМБ


MERS-CoV-ийн халдвар:

Саудын Араб улсын Эрүүл Мэндийн Яамны 2020 оны эпидемиологийн 1 дүгээр долоо хоногийн эргэн мэдээллээр MERS-CoV-ийн халдварын сэжигтэй 2 тохиолдол бүртгэгдсэн байна. Эхний тохиолдол 48 настай, эрэгтэй. Алмедина дүүрэгт амьдардаг. Хоёрдахь тохиолдол 72 настай, эрэгтэй. Ридах дүүрэгт амьдардаг байна. Дээрхи 2 тохиолдол халдвартай тохиолдолтой хавьтал болсон өгүүлэмжгүй байна.

Эх сурвалж: Promed

Гахайн сонгомол мялзан өвчин:

Япон улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2020 оны 01 дүгээр сарын 07-нд Урума хотын Окинавад гахайн сонгомол мялзан өвчин бүртгэгдсэн байна. Нийт 921 өвчилсөн гахайг устгаж, халдваргүйтгэл хийжээ. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Шувууны томуу өвчин:

БНХАУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 12 дугаар сарын 20-нд Чиаяи мужийн шувууны аж ахуйд шувууны томуугийн H5N2 вируст халдварын дэгдэлт бүртгэгдсэн. Нийт 3114 шувуу өртөмхий байснаас, 1000 шувуу өвчилж үхэн, 2114 шувууг устгасан байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.

Эх сурвалж: ДМАЭМБ

Шүлхий өвчин:

БНХАУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 12 дүгээр сарын 30-нд Yizhou дүүрэгт “O” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт 64 үхрийг устгажээ. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

ЗӨСҮТ, Шуурхай удирдлагын нэгж

nczd.eop@gmail.com

eop@nczd.gov.mn